

БАТЛАВ. АЗДТГ-Н ДАРГА



Ж.ГАНБААТАР

2020,10,06

*Нэгдсэн эмнэлэгт автомат мэс заслын ор авах*  
**ҮННИЙ САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: *Нэгдсэн эмнэлэгт автомат мэс заслын ор авах*

Төслийн дугаар: **ХЭАОНӨГ/202009079**

2020 ОН

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020.10.06

Хэntий аймгийн Орон нутгийн өмчийн газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос Хэntий аймгийн Нэгдсэн эмнэлэгт автомат мэс заслын ор нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 төгрөгийг [www.tender.gov.mn-ээр](http://www.tender.gov.mn-ээр) банкны меркантийн системийг ашиглан төлнө. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) хаягаар оролцогч өөрийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээр **2020 оны 10 сарын 13 өдрийн 09,00 цагаас** өмнө илгээнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 10 сарын 13**-ны өдрийн 09,50 цаг-т нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Хэntий Аймгийн ЗДТГ-н 3-р давхар  
Хэntий аймгийн ОНӨГ  
304 тоот өрөө, Утас 70563056**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |  |
|---|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | <b>1.1.</b> Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.   |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | <b>2.1.</b> Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br><b>2.2.</b> Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.   |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | <b>3.1.</b> Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Үнийн санал;<br>(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]  |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | <b>4.1.</b> Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.  |
| <b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд</b> | <b>5.1.</b> Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br><b>5.2.</b> Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.  |
| <b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>           | <b>6.1.</b> Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>45</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.   |
| <b>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</b>            | <b>7.1.</b> Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.<br><b>7.2.</b> Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь <b>ТШӨХ-д</b> заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.<br><b>7.3.</b> Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |

- 8. Гэрээ  
байгуулах эрх  
олгох тухай  
мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<b>ТОӨЗ-НЫХОЛБОДОХЗААЛТ</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
<b>ТОӨЗ 1.1</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Сүүлийн 2 жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан /2018, 2019 он/;</li> <li>- Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж нь 30,0 сая төгрөгөөс багагүй байх /2018, 2019 он/</li> <li>- Сүүлийн 2 жилд санал болгож буй үнээс багагүй үнийн дүн бүхий ижил төстэй ажлыг нэгээс багагүй удаа гүйцэтгэсэн байх, гэрээ болон акт ирүүлэх /2018, 2019 он/</li> <li>- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ санал болгож буй үнээс багагүй байх /дансны баталгаажсан хуулга эсвэл банкны зээл олгох тухай мэдэгдэл/</li> <li>- ТБОНӨХБАУХАТ хуулийн 14-16 зүйлийг хангасныг нотлох баримтууд/татвар, нийгмийн даатгал, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт/</li> <li>- Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар, Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар</li> <li>- Нийлүүлэх барааны бодит зураг, Техникийн тодорхойлолт</li> <li>- Тоног төхөөрөмж нийлүүлэх сүүлийн хугацаа гэрээ байгуулснаас хойш хуанлийн 14 хоног <ul style="list-style-type: none"> <li>- Баталгаат засварын хугацаа 12 сараас багагүй байна.</li> </ul> </li> <li>- Тусгай зөвшөөрөл: Эмнэлэгийн багаж тоног, төхөөрөмж дагалдах хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх</li> </ul>
<b>ТОӨЗ 2.1</b>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: <b>Байгууллагын хаяг: Хэнтий аймгийн ОНӨГ</b></p> <p>Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.meps.gov.mn">www.meps.gov.mn</a>) хаягаар оролцогч өөрийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (pdf)-ээ рилгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Mb, нэг файлын хэмжээ 15 Mb байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 төгрөгийг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-ээр банкны меркантийн системийг ашиглан төлнө.</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.meps.gov.mn">www.meps.gov.mn</a>)-ийн серверийн цагаар тооцогдох тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй</p> <p>Огноо: <b>2020 оны 10 дугаар сарын 13-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>09 цаг 00 минут</b></p>
<b>ТОӨЗ 2.1</b>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p><b>Байгууллагын хаяг: Хэнтий аймгийн ОНӨГ</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>Хэнтий аймгийн ЗДТГ-н байр, 3-р давхар, 304 тоот өрөө</b></p> <p>Огноо: <b>2020 оны 10 дугаар сарын 13-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>09 цаг 50 минут</b></p>
<b>ТОӨЗ 6.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>1 багц</b>

## Серверийн техникийн тодорхойлолт, тоо хэмжээ

### Автомат мэс заслын ор- 1 ширхэг

Мэс заслын орны техникийн үзүүлэлт:

- Мэс заслын ор нь олон үйлдэлт ор байх
- Суурь нь өндөр чанарын зэвэрдэггүй гангаар хийгдсэн байх
- Ширээний хавтан нь өндөр чанарын нүүрстөрөгчийн хуванцар хавтангаар хийгдсэн байх бөгөөд цэвэрлэх, ариутгахад хялбар байх
- Орыг тогтвортой нөхцөлд ажиллуулах Линак моторын системтэй байх
- Цахилгаан тэжээл: 220В /50Гц
- Ширээний урт: 2000мм ± 50мм
- Ширээний өргөн: 500мм ± 20мм
- Тавцангийн максимум болон минимум өндөр :(750-1000) ± 50мм
- Ургаш :≥25°
- Буцах :≥35°
- Зүүн :≥15°
- Толгойн хавтанг дээш хумих: ≥40°
- Толгойн хавтанг доош хумих : ≥90°
- Бүсэлхий хэсгийн тавцан өргөх: ≥100 мм
- Хөлний хавтанг дээш өргөх: ≥90°
- Хөлний хавтанг доош буулгах: ≥90°
- Нурууны хавтанг дээш өргөх: ≥45°


1. **Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл [Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.] гэж бичнэ
2. **Баглаа, боодол:** [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Баглаа боодлын нөхцөлийг цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, далайгаар тээвэрлэх тохиолдолд хөлөг онгоцны тавцан дээр, эсхүл доор тээвэрлэх зэргийг харгалзаж тодорхойлно. Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.]
3. **Бараа хүргэх газар:**Хэнтий аймгийн ЗДТГ
4. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

## БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

БАРААГ ГЭРЭЭ БАЙГУУЛСНААС ХОЙШ 14 ХОНОГТ НИЙЛҮҮЛСЭН БАЙНА.

Нэр	Тодорхой лолт	Тоо ширхэг	Хэмжи х нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгч ийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
<i>Автомат мэс заслын op</i>		1	<i>ш</i>				

# Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

## 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар, тээврийн болон суурьлуулах бусад бүх зардал	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

<b>1. Шалгах болон турших</b>	1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
<b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b>	2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
<b>3. Оюуны өмчийн эрх</b>	3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
<b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>	4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
<b>5. Баталгаат засварын хугацаа</b>	5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>1 жил</b> байна.
<b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>	6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
<b>7. Төлбөр</b>	7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.
<b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>	8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
<b>9. Алданги оногдуулах</b>	9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
<b>10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах</b>	10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
<b>11. Маргааныг шийдвэрлэх</b>	11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]  |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br><br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;<br>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;<br>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;<br>5) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
|   | <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p>  |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>                                  | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага 1 жил<br><br>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]   |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><br>Гэрээний үнийн дүнгийн 100хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)</b>                              | 9.1. Алданги оногдуулах хувь: <b>[0,5%-7 хоногт]</b><br><br>Алдангийн нийт дүн: <b>[ 20% ]</b>   |

## Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>1</sup>

БАТЛАВ.

### ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)
(Албан тушаал)

### НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)
(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нэгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

- Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
- Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>2</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>1</sup> Гэрээ байгуулах үед үүний хасна.

<sup>2</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]